



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Ю.Ганзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн  
 2/д дугаар тогтоолын хавсралт

"Архангай-АЗЗА" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, сэлбэгээр худалдах  
 автомашины жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар          | Үйлдвэр лэсэн он | Нийт гүйлт /км/ | Балансын дүн (төгрөгөөр)                            | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)                   | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) | Сэргээн босголтын зардал (төгрөгөөр) | Сэлбэгээр ашигласнаас олох орлогын доод хэмжээ |
|-----|--|------------------|-----------------|---|---|----------------------------|--------------------------------------|--|
| 1   | Краз-256 маркийн, АРА 11-88 улсын дугаартай, хөдөлгүүр-095192, арал-612188 | 1988             | 259920          | 1,085,400.00  | 1,085,400.00  | 0.00                       |                                      | 250,000.00                                     |
|     |  |                  |                 | 1,085,400.00  |   |                            |                                      | 250,000.00                                     |
|     | НИЙТ   |                  |                 | 1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун) | 1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун) | -                          |                                      | 250,000.00 (хоёр зуун тавин мянга)             |